



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/09/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Нарангэрэл
Утас: 261628 Цахим хаяг: narangerelb@audit.gov.mn
Аудитор: Ч.Дашдаваа
Утас: 261628 Цахим хаяг: dashdavaach@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа	20
4.2 Төлбөрийн акт.....	20
4.3 Албан шаардлага	20
4.4 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААН	Аж ахуйн нэгж
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДС	Нийгмийн даатгалын сан
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Д.ЗОРИГТ ТАНАА

2022.02.24 № 07/348
танай _____-ны № _____-г
Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/	
Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>103,695,716.64</u>	<u>112,411,425.71</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	51,791,224.64	22,456,484.84
312	Банканд байгаа бэлэн мөнгө	51,791,224.64	22,456,484.84
3121	Төгрөг	51,791,224.64	22,456,484.84
31211	Төрийн сангийн харилцах	51,791,224.64	22,456,484.84
33	АВЛАГА	714,470.00	1,357,148.71
335	Бусад авлага	714,470.00	1,357,148.71
3351	Байгууллагаас авах авлага	714,470.00	1,357,148.71
34	УРЬДЧИЛГАА	(0.01)	(0.01)
34600	Урьдчилж гарсан зардал	(0.01)	(0.01)
35	БАРАА МАТЕРИАЛ	51,190,022.01	88,597,792.17
354	Хангамжийн материал	51,190,022.01	88,597,792.17
35420	Аж ахуйн материал	51,190,022.01	57,697,792.17
35470	Бусад хангамжийн материал		30,900,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,424,964,333.37</u>	<u>5,487,076,361.80</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>5,424,964,333.37</u>	<u>5,487,076,361.80</u>
392	Биет хөрөнгө	5,241,508,173.57	5,316,404,115.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,053,156,270.24	5,053,156,270.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	(175,340,527.89)	(260,022,214.03)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	447,180,000.00	134,154,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(428,267,128.17)	(86,294.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	941,262,011.72	624,736,481.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	(726,960,198.67)	(331,445,881.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	366,400,725.92	340,989,085.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(235,922,979.58)	(245,077,330.50)
393	Биет бус хөрөнгө	183,456,159.80	170,672,246.25
39301	Программ хангамж	49,695,386.00	37,828,278.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(28,153,651.20)	(29,070,456.75)
39303	Бусад биет бус хөрөнгө	134,783,039.00	102,107,005.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(32,676,034.00)	-
39305	Бусад биет бус хөрөнгө/Газар/	59,807,420.00	59,807,420.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,528,660,050.01</u>	<u>5,599,487,787.52</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>860,120.00</u>	<u>26,609,713.16</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	860,120.00	26,609,713.16
413	Өглөг	860,120.00	26,609,713.16
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	636,310.00	4,360,138.56
4136	Бусад өглөг	223,810.00	22,249,574.60
41361	Байгууллагад төлөх өглөг	50,000.00	50,000.00
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	173,810.00	22,199,574.60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,527,799,930.01</u>	<u>5,572,878,074.36</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,527,799,930.01	5,572,878,074.36

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,130,919,957.98	2,130,919,957.98
51101	Өмч: - төрийн	2,130,919,957.98	2,130,919,957.98
512	Хуримтлагдсан үр дүн	1,709,253,180.31	1,754,331,324.66
51210	Өмнөх үеийн үр дүн	1,709,253,180.31	1,709,253,180.31
51220	Тайлант үеийн үр дүн		45,078,144.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,687,626,791.72	1,687,626,791.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,528,660,050.01</u>	<u>5,599,487,787.52</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,806,391,531.54	2,916,554,625.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	276,386,081.34	503,955,174.56
120	Нийтлэг татварын бус орлого	276,386,081.34	503,955,174.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	276,386,081.34	503,955,174.56
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	276,386,081.34	503,955,174.56
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,530,005,450.20	2,412,599,451.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,150,485.40	6,202,254.40
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,150,485.40	6,202,254.40
1330	Төсвийн захирагчдаас	56,334,864.80	63,654,297.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,334,864.80	63,654,297.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,430,520,100.00	2,342,742,900.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,430,520,100.00	2,342,742,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,068,208,661.78	2,846,106,106.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,068,208,661.78	2,846,106,106.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,791,073,256.20	2,691,451,301.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,627,593,715.34	1,543,048,832.85
210101	Үндсэн цалин	1,234,537,523.34	1,150,268,181.85
210102	Нэмэгдэл	393,056,192.00	392,780,651.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	213,507,343.43	202,498,642.00
210201	Тэтгэврийн даатгал	142,921,815.69	140,108,810.40
210202	Тэтгэмжийн даатгал	17,657,057.30	15,592,395.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,112,835.40	12,473,916.35
210204	Ажилгүйдлийн даатгал	3,522,871.17	3,118,479.09
210205	Эрүүл мэндийн даатгал	35,292,763.87	31,205,040.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,979,264.44	36,873,878.95
210301	Гэрэл, цахилгаан	17,892,083.95	19,848,668.42
210302	Түлш, халаалт	8,805,303.73	12,827,931.53
210303	Цэвэр, бохир ус	3,281,876.76	4,197,279.00
2104	Хангамж, бараа материалын зардал	121,986,579.58	104,525,363.83
210401	Бичиг хэрэг	29,545,226.00	21,307,230.00
210402	Тээвэр, шатахуун	21,208,667.00	16,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	23,917,959.59	21,425,476.23
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	450,000.00	8,325,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	46,864,726.99	37,467,657.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,259,398.00	16,399,899.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,815,248.00	8,899,899.00
210604	Урсгал засвар	17,444,150.00	7,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	27,213,540.00	24,774,160.00
210702	Дотоод албан томилолт	27,213,540.00	24,774,160.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	251,292,428.01	343,190,053.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	246,095,386.01	339,090,924.46
210803	Даатгалын үйлчилгээ	3,144,688.00	3,074,240.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	373,004.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		132,000.00
210807	Газрын төлбөр	1,518,650.00	247,469.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	160,700.00	145,420.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	483,240,987.40	420,140,471.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	123,083,617.00	80,808,324.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	48,521,514.00	94,135,334.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	311,635,856.40	245,196,812.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	277,135,405.58	154,654,804.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	160,055,072.00	60,008,436.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	61,290,119.00	54,701,973.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	98,764,953.00	5,306,463.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	117,080,333.58	94,646,368.76
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,080,333.58	94,646,368.76
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(261,817,130.24)</u>	<u>70,448,519.45</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,261,580.83	25,370,375.10
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	10,261,580.83	18,231,571.50
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		7,138,803.60
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	<u>(10,261,580.83)</u>	<u>(25,370,375.10)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(272,078,711.07)</u>	<u>45,078,144.35</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,130,919,957.98	1,687,626,791.72	1,980,381,901.38	5,798,928,651.08
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			949,990.00	949,990.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,130,919,957.98	1,687,626,791.72	1,981,331,891.38	5,799,878,641.08
Тайлант үеийн үр дүн			(272,078,711.07)	(272,078,711.07)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,130,919,957.98	1,687,626,791.72	1,709,253,180.31	5,527,799,930.01
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,130,919,957.98	1,687,626,791.72	1,709,253,180.31	5,527,799,930.01
Тайлант үеийн үр дүн			45,078,144.35	45,078,144.35
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,130,919,957.98	1,687,626,791.72	1,754,331,324.66	5,572,878,074.36

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,767,124,587.20	2,982,269,774.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	237,119,137.00	547,644,558.00
120	Нийтлэг татварын бус орлого	237,119,137.00	547,644,558.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	185,251,452.00	168,829,731.00
120009	Бусад орлого	51,867,685.00	378,814,827.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	185,251,452.00	168,829,731.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,530,005,450.20	2,434,625,216.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,150,485.40	28,228,019.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		22,025,764.60
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,150,485.40	6,202,254.40
1330	Төсвийн захирагчдаас	56,334,864.80	63,654,297.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,334,864.80	63,654,297.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,430,520,100.00	2,342,742,900.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,330,520,100.00	1,242,742,900.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,100,000,000.00	1,100,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,795,784,729.80	3,011,604,513.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,795,784,729.80	3,011,604,513.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,518,649,324.22	2,916,332,637.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,636,950,512.98	1,543,570,625.00
210101	Үндсэн цалин	1,144,866,196.17	1,175,797,045.91
210102	Нэмэгдэл	492,084,316.81	367,773,579.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	213,261,638.20	198,895,700.00
210201	Тэтгэврийн даатгал	149,414,435.55	137,615,934.83
210202	Тэтгэмжийн даатгал	16,181,516.77	15,314,968.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,847,993.67	12,251,975.12
210204	Ажилгүйдлийн даатгал	3,165,053.73	3,062,993.78
210205	Эрүүл мэндийн даатгал	31,652,638.48	30,649,827.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,979,264.44	36,873,878.95
210301	Гэрэл, цахилгаан	17,892,083.95	19,848,668.42
210302	Түлш, халаалт	8,805,303.73	12,827,931.53
210303	Цэвэр, бохир ус	3,281,876.76	4,197,279.00
2104	Хангамж, бараа материалын зардал	106,776,216.59	110,114,033.83
210401	Бичиг хэрэг	27,117,390.00	24,552,600.00
210402	Тээвэр, шатахуун	21,208,667.00	16,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	23,917,959.59	21,425,476.23
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	450,000.00	8,325,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	34,082,200.00	39,810,957.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,193,867.00	37,531,096.40

210601	Багаж, техник, хэрэгсэл	21,749,717.00	30,031,096.40
210604	Урсгал засвар	17,444,150.00	7,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	52,513,198.00	24,774,160.00
210702	Дотоод албан томилолт	27,213,540.00	24,774,160.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	25,299,658.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	391,453,113.01	870,437,808.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	297,161,071.01	398,473,852.46
210803	Даатгалын үйлчилгээ	3,144,688.00	3,074,240.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	373,004.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		132,000.00
210807	Газрын төлбөр	1,518,650.00	247,469.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	160,700.00	145,420.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	89,095,000.00	89,050,000.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	-	378,814,827.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,521,514.00	94,135,334.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	48,521,514.00	94,135,334.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	277,135,405.58	95,271,876.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	160,055,072.00	60,008,436.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	61,290,119.00	54,701,973.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	98,764,953.00	5,306,463.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	117,080,333.58	35,263,440.76
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,080,333.58	35,263,440.76
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(28,660,142.60)	(29,334,739.80)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(28,660,142.60)	(29,334,739.80)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	80,451,367.24	51,791,224.64
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	51,791,224.64	22,456,484.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		51,791,224.64	(51,791,224.64)	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,512,742,900.00	2,480,580,559.24	32,162,340.76	98.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,512,742,900.00	2,480,580,559.24	32,162,340.76	98.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,458,336,400.00	2,426,180,123.24	32,156,276.76	98.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,543,805,000.00	1,543,570,625.00	234,375.00	100.0
210101	Үндсэн цалин	1,148,945,800.00	1,145,282,264.77	3,663,535.23	99.7
210102	Нэмэгдэл	281,757,200.00	286,992,610.08	(5,235,410.08)	101.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	113,102,000.00	111,295,750.15	1,806,249.85	98.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	198,895,700.00	198,895,700.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	138,038,500.00	138,038,500.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	15,214,300.00	15,214,300.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,171,400.00	12,171,400.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,042,900.00	3,042,900.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	30,428,600.00	30,428,600.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,372,500.00	36,873,878.95	498,621.05	98.7
210301	Гэрэл, цахилгаан	19,872,500.00	19,848,668.42	23,831.58	99.9
210302	Түлш, халаалт	13,600,000.00	12,827,931.53	772,068.47	94.3
210303	Цэвэр, бохир ус	3,900,000.00	4,197,279.00	(297,279.00)	107.6
2104	Хангамж, бараа материалын зардал	112,358,900.00	110,114,033.83	2,244,866.17	98.0
210401	Бичиг хэрэг	25,000,000.00	24,552,600.00	447,400.00	98.2
210402	Тээвэр, шатахуун	16,000,000.00	16,000,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	23,000,000.00	21,425,476.23	1,574,523.77	93.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,358,900.00	8,325,000.00	33,900.00	99.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,000,000.00	39,810,957.60	189,042.40	99.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,000,000.00	18,935,672.00	64,328.00	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,500,000.00	11,435,672.00	64,328.00	99.4
210604	Урсгал засвар	7,500,000.00	7,500,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	25,000,000.00	24,774,160.00	225,840.00	99.1
210702	Дотоод албан томилолт	25,000,000.00	24,774,160.00	225,840.00	99.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	436,904,300.00	408,626,053.46	28,278,246.54	93.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	339,904,300.00	315,476,924.46	24,427,375.54	92.8
210803	Даатгалын үйлчилгээ	4,000,000.00	3,074,240.00	925,760.00	76.9

210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	500,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	132,000.00	668,000.00	16.5
210807	Газрын төлбөр	2,000,000.00	247,469.00	1,752,531.00	12.4
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	600,000.00	145,420.00	454,580.00	24.2
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	89,100,000.00	89,050,000.00	50,000.00	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,000,000.00	84,390,000.00	610,000.00	99.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	85,000,000.00	84,390,000.00	610,000.00	99.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,406,500.00	54,400,436.00	6,064.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,406,500.00	54,400,473.00	6,027.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,306,500.00	5,306,500.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	49,100,000.00	49,093,973.00	6,027.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,512,742,900.00	2,420,027,362.24	92,715,537.76	96.3
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,342,742,900.00	2,310,580,559.24	32,162,340.76	98.6
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,242,742,900.00	1,210,580,559.24	32,162,340.76	97.4
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,100,000,000.00	1,100,000,000.00	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	170,000,000.00	109,446,803.00	60,553,197.00	64.4
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	170,000,000.00	109,446,803.00	60,553,197.00	64.4
	Тохируулгын орлого, зарлагын дүн		31,218,457.20		
	Эцсийн үлдэгдэл		22,456,484.84		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	89	89		
620001	Удирдах ажилтан	10	10		
620002	Гүйцэтгэх ажилтан	72	72		
620004	Гэрээт ажилтан	7	7		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад бүтэц орон тоог оновчтой зохион байгуулах, автомашины шатахуун зарцуулалтын нормыг тогтоож, зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 сарын 24-нээс 2022 оны 02 дугаар сарын 23-ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор Б.Нарангэрэл, аудитор Ч.Дашдаваа нар хариуцан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Сэржмядаг, Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 01/133 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нийгмийн даатгалын ерөнхий газрын эрхэм зорилго нь даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэхэд оршино.

Нийгмийн даатгалын байгууллага 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий даатгагч болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дотоод аудит, мониторингийн газраас Ковид-19 цар тахлын улмаас санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудит хийж боломжит түвшинд ажиллаж байна гэсэн үнэлэлт өгчээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй, хөтөлбөр арга хэмжээгээрх төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитад ирүүлээгүйг тайлангийн хугацаанд залруулан авсан.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,068,208.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 30,682.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нийгмийн даатгалын ерөнхий газар 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 70827.7 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар өсөж, материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	51,791.2	22,456.5	(29,334.7)
Урьдчилж гарсан тооцоо	714.5	1,357.1	642.6
Бараа материал	51,190.0	88,597.8	37,407.8
Үндсэн хөрөнгө	5,424,964.3	5,487,076.4	62,112.1
Нийт хөрөнгө	5,528,660.0	5,599,487.8	70,827.8
Өр төлбөр	860.1	26,609.7	25,749.6
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,527,799.9	5,572,878.1	45,078.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,528,660.0	5,599,487.8	70,827.8

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны өмнөх оны үлдэгдэл нь олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн төслийн санхүүжилтийн үлдэгдэл бөгөөд тайлант онд зарцуулж 29,334.7 мянган төгрөгөөр буурсан;
- Бараа материалын данс тайлант онд үнэт цаас, маягтын зарцуулаагүй үлдэгдэл 30,900.0 мянган төгрөг байгаагаас шалтгаалан өссөн;
- Үндсэн хөрөнгө данс тайлант онд Дэлхийн банкны төслийн санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Майтеч ХХК-тай байгуулсан гэрээний дагуу нийлүүлсэн 39,489.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг балансаас балансад шилжүүлэн авснаас голлон шалтгаалсан;

- Өр төлбөр дансны үлдэгдэл Олон улсын хөдөлмөрийн байгууллага, НДЕГазартай хамтран хэрэгжүүлсэн төслийн хэрэгжээгүй арга хэмжээний 22,025.8 мянган төгрөгийн санхүүжилтийг тооцоо нийлэн өглөгөөр бүртгэснээс шалтгаалжээ.
- Цэвэр хөрөнгө өмчийн дүн тайлант хугацааны үр дүнгээр өссөн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,839,948.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,839,948.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс цалин хөлстэй холбоотой зардлыг 205,390.43 мянган төгрөг, томилолт зочны зардлыг 197,407.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 688,572.9 мянган төгрөг зэргээр нийт 1,302,533.9 мянган төгрөгөөр бууруулж 2,537,413.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор батлагдсан төсвийг 24,671.0 мянган төгрөгөөр бууруулан 2,512,742.9 мянган төгрөг болгон тодотгол хийсэн.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,242,742.9 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангаас, 1,100,000.0 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 170,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангаас 1,242,742.9 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,100,000.0 мянган төгрөг, маягт, түрээсийн орлогоос 170,000.0 мянган төгрөг нийт 2,512,742.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,480,580.6 мянган төгрөгийг зарцуулж, 32,162.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2480,580.6 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 25,820.2 мянган төгрөг, Хангамж, бараа материалын зардлыг 2,244.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71901	Нийгмийн даатгал	2,512,742.9	2,480,580.6	32,162.3	98.7
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,118,432.1	2,110,703.2	7,728.9	99.6
1.2	80103	Гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээ	88,687.5	86,229.4	2,458.1	97.2
1.3	80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	62,573.8	60,868.5	1,705.3	97.3
1.4	80213	Өмгөөлөл, хуулийн зөвлөх үйлчилгээ	9,900.0	9,500.0	400.0	95.9
1.5	80219	Харуул, хамгаалалтын зардал	33,510.0	32,739.7	770.3	97.7
1.6	80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	145,233.0	126,139.3	19,093.7	86.6
1.7	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	5,306.5	5,306.5	0	100.0
1.8	80820	Бусад тусламж, дэмжлэг	49,100.0	49,094.0	6,026.0	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансны эхний үлдэгдэл 45,787.1 мянган төгрөг, Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас хэрэгжүүлсэн төслийн ажлын үлдэгдэл санхүүжилт 28,228.0 мянган төгрөг, нийт 28,228.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тоног төхөөрөмжийн зардалд 18,595.4 мянган, сургалтын зардалд 9,745.3 мянган, гарын авлага материалын зардалд 6,076.0 мянган нийт 54,724.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 22,060.4 мянган төгрөг байна.

Тус нэмэлт санхүүжилтийн орлого нь Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн биелэлтийн хувь 98.7 хувьтай байна.

Тайлант онд хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал болон хөрөнгийн зардалд нийт 2,512,742.9 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,480,580.6 мянган төгрөг зарцуулж 98.7 хувийн биелэлттэй байна.

Хөтөлбөр, арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийн биелэлт түүнийг хэрэгжүүлэхээр баталсан төсвийн гүйцэтгэлийн биелэлт 1.3 хувиар зөрүүтэй буюу төсвийг хэмнэлттэй зарцуулж байгууллагын хүрэх үр дүнд хүрч ажилласан байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын орон тоо, бүтэц зохион байгуулалтыг Монгол улсын Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 05 сарын 15 өдрийн А/112 дугаар тушаалаар 89 орон тоотой байхаар баталсан. Үүнээс удирдах 10, гүйцэтгэх 72, гэрээт 7 ажилтантайгаар баталсан нь бүтэц орон тоо оновчгүй, гэрээгээр ажиллаж буй үйлчилгээний ажилтнуудад үндсэн цалин дээр ур чадварын нэмэгдэл, шагналт цалинг төсвийн тухай хууль зөрчин олгож байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд анхаарал татсан асуудал гараагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын ерөнхий газрын санхүүгийн бүртгэлд ашиглаж байгаа “Санхүү” программ хангамж нь Сангийн сайдын баталсан заавар журмын дагуу тайлан мэдээ бэлтгэн боловсруулдаггүй. Тухайлбал,

- Санхүүгийн тайлан тодруулгыг иж бүрэн бэлтгэдэггүй, ерөнхий дэвтрийн хураангуй бүртгэл, мөнгөн гүйлгээний журналыг боловсруулан гаргадаггүй, боловсруулалтыг автоматаар хийдэггүй байна,
- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналаар тооцсон элэгдлийн зардлын дүн ерөнхий журналын дүнгээс зөрүүтэй гаргадаг,
- Санхүүгийн тайлангийн аудит хийхэд хялбар биш зэрэг алдаа гарч байна.

Санхүүгийн тайлангийн аудит хийхэд хялбар биш зэрэг алдаа гарч байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь тайлант хугацаанд оруулбал зохих 119 мэдээллээс хугацаандаа оруулсан 104 мэдээлэл, 607,178,440.0 мянган төгрөгийн 14 мэдээллийг хугацаа хоцроосон зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол шуурхай оруулж байх, албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заалттай нийцэхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ЭМДС-аас НДС-ийн үйл ажиллагаанд олгодог эрүүл мэндийн даатгалын орлогын байцаагчдын зардал 1,100,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг НДЕГГазрын төсвийн үйл ажиллагааны санхүүжилтэд авч зарцуулсан, тус зардлыг хэрхэн тооцож, хянаж, зарцуулах журам байхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын байгууллагад өгсөн санхүүжилтийг Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын санд хуваарилах холбогдох хууль, дүрэм журмыг боловсруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын сангаас Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд олгодог эрүүл мэндийн даатгалын орлогын байцаагчдын зардлын санхүүжилтийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын төсвийн үйл ажиллагааны санхүүжилтэд авч зарцуулсан, тус зардлыг хэрхэн тооцож, хянаж, зарцуулах журам байхгүй байгаа нь Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1.4-т "Нийгмийн даатгалын байгууллагад олгох", Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1-д "Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо нь нийгмийн даатгалын төв байгууллага, орон нутгийн салбар нэгж, /төлөөлөгч, байцаагч/-аас бүрдэнэ" гэж заасантай заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 451,400.2 мянган төгрөгийн 7 зөвлөмжийн биелэлт 82.9 хувь, 4 албан шаардлагын биелэлт 79.3 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	-	4	-	-	-	79.3
Зөвлөмж	7	451,400.2	5	324,626.8	2	126,773.4	82.9
Нийт дүн	11	30,450.0	2	26,585.4	1	3,864.6	81.1

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай”-д заасан зардлын эдийн засгийн ангиллын хүрээнд батлагдсан төсөвтөө багтааж үйл ажиллагаа явуулсан эсэхийг дараагийн аудитаар авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 45,456.2 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс, 22,060.4 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 178.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,778.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 17,438.3 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 8 алдаа, зөрчлийн дүн 23,395.8 төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 30,682.1 мянган төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлангийн бусад өглөгийг 22,060.4 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.

4.2 Төлбөрийн акт

1.Шатахууны зардлыг тогтоосон нормоос 178.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн олгосон.

Авто тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т "тээвэрлэлтийн үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн техник ашиглалтын талаар нийтлэг мөрдөх дүрэм, журам, норм, нормативыг батлах, тэдгээрийн биелэлтийг хангуулах", Зам , тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг баримталж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг баримтлан ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх, Төлбөрийн акт.

4.3 Албан шаардлага

1.Тайлант онд батлагдсан орон тооноос илүү хөлсөөр ажиллуулж байгаа үйлчилгээний 4 ажилтанд ур чадварын нэмэгдэл 3,577.1 мянган төгрөг, шагналт цалин 2,201.5 мянган төгрөг нийт 5,778.6 мянган төгрөгийг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" 16.5.9-д "байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох", Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/112 тушаалын хавсралтад Нийгмийн даатгалын ерөнхий газар гэрээт ажилтан 7 гэж заасныг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан ажиллагчдын цалин хөлсийг тогтоох, зөрчлийг давтан гаргахгүй байх, Албан шаардлага өгөх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Өмнө ажиллаж байсан ажилтантай холбоотой үүссэн 714.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцоо тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төлбөр тооцоо тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, хариуцагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд 208 ААН-тэй хийсэн 250,656.7 мянган төгрөгийн худалдан авалтыг и-баримттай тулган шалгахад 17 ААН-ээс 10,673.0 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм гэсэн заалтын дагуу төлбөрийн баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, харилцагч байгууллагаас бүрэн гаргуулан авахад хяналт тавьж ажиллах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төлбөрийн баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, харилцагч байгууллагаар татварын цахим системд төлбөрийн е-баримтыг бүрэн шивүүлэх ажлыг зохион байгуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх

3. Цалин нийгмийн даатгалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд цалингийн зардлыг 145.9 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.1-д "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлох, зөрчлийг давтан гаргахгүй байх

4. Шатахууны зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2 дэд дарга, Тамгын газрын дарга нар албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан биш бөгөөд албан хэрэгцээндээ автомашин хэрэглэж 5,905.0 мянган төгрөгийн шатахууны зардал гаргасан.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын 2-т "Албан тушаалын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор хуанлийн хоног (баярын болон долоо хоногийн амралтын өдрийг оролцуулан)-т дунджаар 70 км, албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км, дуудлагын автомашины хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж 2500 см³-ээс илүүгүй байхаар тогтоож, ажлын хоногт дунджаар 40 км-ээс тус тус хэтрүүлэхгүй хэрэглэж байхаар тогтоосугай" гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх ба эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Албан ажлын суудлын автомашин хэрэглэхдээ автомашины зардлыг төсөвт тусган гүйцэтгэлээр санхүүжүүлэх ажлыг зохион байгуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх

5. Тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын баталсан маягт аргачлалын дагуу хөтөлбөр, арга хэмжээний төсөв, гүйцэтгэлийн биелэлт, хүрсэн үр дүн түүний танилцуулга, төсвийн тохируулгын тайлан, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайлангийн танилцуулгыг хуулиар заасан хугацаанд иж бүрэн хийж ирүүлээгүй. Энэ нь:

- Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл 54.5-д Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна; 54.5.1-д тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/; 54.5.3-д тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл; 54.5.4-д хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/; 54.5.5-д нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга;
- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар батлах журмын 2 дугаар хавсралт;
- Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журмын 1 дүгээр хавсралт 1.4-д Төсвийн эрх захирагч нь төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлант оны төсвийн хэтрэлт, хэмнэлт түүнд нөлөөлсөн хүчин зүйлийн талаарх дэлгэрэнгүй тайлбар танилцуулга хавсаргана, 2.3-д Төсвийн байгууллага нь төсвийн гүйцэтгэлийн тохируулгыг ТГТ-1 а маягтын дагуу гарган төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хамт дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг иж бүрэн гаргаж хэвших, Сангийн сайдын тушаалуудаар батлагдсан журмуудын дагуу санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангуудад тодруулга, танилцуулга тайлбар бэлтгэх ажлыг зохион байгуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/ д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс												
					Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцл ага тооцох		Зөвлөмж						
					т о о	Дүн	т о о	Дүн	т о о	Дүн	т о о	дүн	т о о	Дүн	т о о	дүн			
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																			
1	НДЕГ	АХГ-2022/09/НА-СТА-ТШЗ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага, НДЕГ-тай хамтран хэрэгжүүлсэн "Нийгмийн даатгалыг албан бус эдийн засагт өргөжүүлэх", "Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх" төслийн санхүүжилтийн үлдэгдэл 22,060.4 мянган төгрөгийг өглөгөөр бүртгээгүй.	Санхүүгийн байдлын тайлангийн бусад өглөгийг дутуу илэрхийлсэн.	1	22,060.4	1	22060.4											
2	НДЕГ	АХГ-2022/09/НА-СТА-ТШЗ	Шатахууны зардлыг тогтоосон нормоос 178.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн олгосон.	Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг баримтлан ажиллах	1	178.9			1	178.9									
3	НДЕГ	АХГ-2022/09/НА-СТА-ТШЗ	Тайлант онд батлагдсан орон тооноос илүү хөлсөөр ажиллуулж байгаа үйлчилгээний 4 ажилтанд ур чадварын нэмэгдэл 3,577.1 мянган, шагналт цалин 2,201.5 мянган төгрөг нийт 5,778.6 мянган төгрөгийг олгосон.	Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан ажиллагчдын цалин хөлсийг тогтоох олгосон.	1	5,778.6					1	5,778.6							
4	НДЕГ	АХГ-2022/09/НА-СТА-ТШЗ	Өмнө ажиллаж байсан ажилтантай холбоотой үүссэн 714.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй	Төлбөр тооцоо тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, хариуцагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах	1	714.4											1	714.4	
5	НДЕГ	АХГ-2022/09/НА-СТА-ТШЗ	Тайлант онд 208 ААН-тэй хийсэн 250,656.7 мянган төгрөгийн худалдан авалтыг и-баримттай тулган шалгахад 17 ААН-ээс 10,673.0 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна.	Төлбөрийн баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, харилцагч байгууллагаас бүрэн гаргуулан авах ажлыг зохион байгуулах	1	10,673.0											1	10,673.0	

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6	НДЕГ	АХГ-2022/09/НА-СТА-ТШЗ	Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд цалингийн зардлыг 145.9 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.	Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлох	1	145.9								1	145.9	
7	НДЕГ	АХГ-2022/09/НА-СТА-ТШЗ	Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2 дэд дарга, Тамгын газрын дарга нар албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан биш бөгөөд албан хэрэгцээндээ автомашин хэрэглэж 5,905.0 мянган төгрөгийн шатахууны зардал гаргасан.	Албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрхгүй албан тушаалтан автомашин гаргуулан хэрэглэхгүй байх, шатахууны зардлыг төлүүлэхгүй байх	1	5,905.0								1	5,905.0	
8	НДЕГ	АХГ-2022/09/НА-СТА-ТШЗ	Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын баталсан маягт аргачлалын дагуу хөтөлбөр, арга хэмжээний төсөв, гүйцэтгэлийн биелэлт, хүрсэн үр дүн түүний танилцуулга, төсвийн тохируулгын тайлан, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайлангийн танилцуулгыг хуулиар заасан хугацаанд иж бүрэн хийж ирүүлээгүй.	Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 76, 388 дугаар тушаалуудын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	1									1		
Дүн					8	45,456.2	1	22,060.40	1	178.9	1	5,778.6	-	-	5	17,438.3
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	НДЕГ	АХГ-2022/09/НА-СТА-ТШЗ	ЭМДС-аас НДС-ийн үйл ажиллагаанд олгодог эрүүл мэндийн даатгалын орлогын байцаагчдын зардал 1,100,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг НДЕГ-аар авч зарцуулсан, тус зардлыг хэрхэн тооцож, хянаж, зарцуулах журам байхгүй.	Нийгмийн даатгалын байгууллагад өгсөн санхүүжилтийг Аймаг, нийслэл, дүүргийн НДСанд хуваарилах	1	1,100,000.0								1	1,100,000.0	
2	НДЕГ	АХГ-2022/09/НА-СТА-ТШЗ	Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа. Нийгмийн даатгалын ерөнхий газар тайлант онд 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 607,178.4 мянган төгрөгийн 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.	Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх	1	607,178.4								1	607,178.4	
Дүн					2	1,707,178.4	0	0	0	0	2	1,707,178.4	-	-	0	0
Нийт дүн					10	1,752,634.6	1	22,060.4	1	178.9	3	1,712,957.0	-	-	5	17,438.3



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 09 дугаар сарын 25 № 18/0170069
АХТ-2022/09/НА-СТА-ТЦЗ
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шатахууны зардлыг тогтоосон нормоос 178,981.00 төгрөгөөр хэтрүүлэн олгосон.

Энэ нь авто тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 "тээвэрлэлтийн үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн техник ашиглалтын талаар нийтлэг мөрдөх дүрэм, журам, норм, нормативыг батлах, тэдгээрийн биелэлтийг хангуулах", Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**


1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын шатахууны зардлыг тогтоосон нормоос илүү олгосон 178,981.0 /Нэг зуун далан найман мянга есөн зуун наян нэгэн төгрөг 00 мөнгө/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкн дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригт, үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч П.Адъяасүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

(Handwritten signatures)

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ч.ДАШДАВАА



9006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10\Bichig_Khereg\Akr\2022\0225 Auditin 2 Gazar-20.Docx

001030076



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 90/А0170069
АХТ - 2022/09/НА - СТА-ТЦЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд олгодог эрүүл мэндийн даатгалын орлогын байцаагчдын зардалд 1,100,000,000.00 төгрөгийн санхүүжилт олгосон ба тус зардлыг хэрхэн тооцож, хянаж, зарцуулах журам байхгүй байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Нийгмийн даатгалын байгууллагад олгох", Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо нь нийгмийн даатгалын төв байгууллага, орон нутгийн салбар нэгж, /төлөөлөгч, байцаагч/-аас бүрдэнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цаашид Эрүүл мэндийн даатгалын сангаас Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд олгодог санхүүжилтийг Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын санд хуваарилан шилжүүлэх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий дарга Д.Зоригт, Үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч П.Адъяасүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ч.ДАШДАВАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-90.Docx

CO10800292



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 91/АО170069

Улаанбаатар хот

АХТ-2022/09/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд батлагдсан орон тооноос илүү хөлсөөр ажиллуулж байгаа үйлчилгээний 4 ажилтанд ур чадварын нэмэгдэл 3,577,116.00 төгрөг, шагналт цалин 2,201,515.00 төгрөг нийт 5,778,631.00 төгрөгийг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" 16.5.9 " ...байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох", Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/112 тушаалын хавсралтад Нийгмийн даатгалын ерөнхий газар гэрээт ажилтан 7 гэж заасныг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий дарга Д.Зоригт, Үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч П.Адъяасүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ч.ДАШДАВАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 15 № 92/АУТ70069

Улаанбаатар хот

АТТ - 2022/09/НА - АТН - ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газар тайлант онд 119 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 607,178,440.00 төгрөгийн 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4 "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий дарга Д.Зоригт, Үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч П.Адъяасүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ч.ДАШДАВАА